

## Тойм ба үндэслэл

Үзүүлэлт	<b>3. Хамт олон, бүлэг, хувь хүн, соёл, өв уламжлалын салбарт ажиллаж байгаа хүмүүст сургалт явуулдаг эсэх.</b>	
Үнэлгээний хүчин зүйлүүд	Энэ үзүүлэлтийг оролцогч талуудаар хянуулж, тайлагнасан үндэсний түвшний хоёр хүчин зүйл дээр үндэслэн үнэлдэг:	
	3.1 Сургалтын хөтөлбөрүүд дотроос нөхөрлөлүүд өөрсдөө хэрэгжүүлэх нь олон нийт, бүлгүүд, хувь хүмүүст чиглэсэн СББӨ-н чадавхийг бэхжүүлэх боломжийг олгодог.	Зүйл 14: (a)(ii) OD 82, OD 153(b), OD 155(b)
	3.2 Сургалтын хөтөлбөрүүд нь соёл болон өвийн салбарт ажиллаж буй хүмүүст хүртээмжтэй байдлаар чиглэсэн СББӨ-н чадавхийг бэхжүүлэх боломжийг олгодог.	Зүйл: 14(a)(iii) OD 153(b)
<b>ТХЗ болон бусад үзүүлэлтийн холбоо хамаарал</b>	<p><b>Тогтвортой хөгжлийн зорилгууд:</b> Бусад үзүүлэлтүүдийн адил энэ үзүүлэлт нь ТХЗ-н 11.4 “Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах, хамгаалах хүчин чармайлтыг бэхжүүлэх”-тэй бүрэн холбогдож байна. Хэрвээ хөгжиж буй улс өөрийн чадавхыг бэхжүүлэхийн тулд олон улсын туслалцаа дэмжлэг авах нь ТХЗ-н зорилго 17.9 “Хөгжиж буй орнуудад үр дүнтэй, зорилтот чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд олон улсын дэмжлэг үзүүлэх”-тэй нийцэж байгаа юм. Энэхүү үзүүлэлт нь мөн “Тогтвортой хөгжлийг дэмжих, соёлын тогтвортой хөгжилд оруулсан хувь нэмрийг үнэлэхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг суралцагчдад эзэмшүүлэхэд чиглэсэн” ТХЗ-н 4.7-г дэмжиж байгаа юм.</p> <p><b>Бусад үзүүлэлтийн холбоо хамаарал:</b> Үзүүлэлт-2 нь СББӨ-ийн хамгаалалт, менежментийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрүүдийг санал болгож буй институт, байгууллагуудад төвлөрдөг бол энэ үзүүлэлт нь тэдгээр хөтөлбөрт хамрагдсан хүмүүс рүү илүүтэйгээр чиглэгддэг. Энд СББӨ-ийн хамгаалалт, менежментийн чадавхыг бэхжүүлэхэд анхаарлаа хандуулж байгаа нь энэ үзүүлэлтийг СББӨ-ийн дадлага, дамжуулалтыг хүндэтгэхтэй шууд холбоотой 4,5,6-р үзүүлэлтээс ялгаж байна.</p>	
<b>Үйл ажиллагааны үндэслэл</b>	Энэ конвенци нь чадавхыг бэхжүүлэх олон нийт болон бүлгүүд (14(a)(ii) зүйл) ба тэдгээрийн СББӨ-ийн хамгаалалт, менежментэд (14(a)(iii) зүйл) мэргэжлийн хувьд оролцогчийг хоёуланд онцолсон. Хэрэв олон нийт, бүлгүүд болон хувь хүмүүс хамгаалалтад аль болох өргөнөөр оролцож, түүнийг удирдахад идэвхтэй оролцохыг хүсвэл (15-р зүйл) хараахан эзэмшээгүй байгаа тусгай ур чадвар, арга барилыг эзэмших шаардлага үүсэж болзошгүй. Үүний нэгэн адил соёл, өвийн чиглэлийн мэргэжлийн ажилтнууд тэднийг дэмжин туслах өргөн мэдлэг, туршлагатай ч СББӨ-н хамгаалалт, менежментэд тохирсон тусгай арга барилын талаар мэдлэг дутмаг байж болно. Чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаанд хүртээмжтэй байх ерөнхий ач холбогдолыг санаж СББӨ-д хамгийн их оролцдог тодорхой тойргийг чиглүүлэх нь илүү зүйтэй.	
<b>Түлхүүр үг</b>	<ul style="list-style-type: none"> <li>● Сургалт</li> <li>● Чадавхийг бэхжүүлэх</li> <li>● Хамт олон, бүлэг, хувь хүн</li> <li>● Inclusive/inclusively</li> </ul>	

## Specific guidance on monitoring and periodic reporting

<p><b>Хяналтын ач тус</b></p>	<p>Үзүүлэлт-2 нь чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийн хүртээмжид анхаарлаа хандуулдаг бол эдгээр нь хэд хэдэн зорилтот хэрэглэгчдэд үр дүнтэй хүрч байгаа эсэхэд анхаарлаа хандуулах. Иймээс улс орны түвшинд хяналт хийх нь ийм хөтөлбөрийг зохион байгуулж байгаа хүмүүс болон төрийн албан тушаалтнуудад (зарим тохиолдолд санхүүжилт олгодог байж болно) зорилтот үзэгчдэд хүрэх сургалтыг бодитоор үзүүлж байгаа эсэх, зохицуулалт хийх шаардлагатай эсэх талаар санал хүсэлтийг өгдөг. Дэлхийн түвшинд хяналт тавьж, тайлагнах нь чадавхыг бэхжүүлэх үйлчилгээг үр дүнтэй хүргэх сайн загваруудыг тодорхойлоход тусалж, бусад улс орнуудад тэдний үр нөлөөг харуулсан арга барил, аргуудын талаар суралцахад тусална.</p>
<p><b>Мэдээллийн эх сурвалж</b></p>	<p>Сургалтын хөтөлбөрийн үйл ажиллагааг хүлээн авагч болон үр шимийг хүртэгчдийн мэдээлэл нь чухал эх сурвалж болж өгдөг. Үүнийг ихэвчлэн түншүүд эсвэл олон нийтэд зориулсан сургалтын хөтөлбөрийн дараа ирүүлсэн тайлангаас олдог. Ийм тайлангууд нь: дадлагажигч нар нь олон нийт эсвэл бүлгүүдийн гишүүн эсэхийг (Үнэлгээний хүчин зүйл 3.1) эсвэл соёл, өвийн чиглэлээр мэргэжлийн эсэхийг (Үнэлгээний хүчин зүйл 3.2) тодорхойлно. Оролцогчдын нас, хүйс, хэл, үндэс угсаа гэх мэтээр ялгах өгөгдлөөр хамрагдах байдлыг хянаж болно. Боломжтой бол суралцагсдын дунд болон урт хугацааны хяналт нь сургалтын хөтөлбөрийн явцад олж авсан ур чадвар, мэдлэгээ хэр зэрэг ашигласан эсэхийг хянах боломжтой.</p> <p><b>Боломжит эх сурвалжууд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>● Чадавхжуулах хөтөлбөр болон үйл ажиллагааны оролцогчдын жагсаалт, төслийн тайлан</li> <li>● Төслийн тайлангууд, сургалтын хөтөлбөр, үйл ажиллагаанд оролцогсдын жагсаалт</li> <li>● Сургалтад оролцогчдын үнэлгээ (сургалтын төгсгөлд, боломжтой бол дараа нь)</li> <li>● ТББ болон олон нийтийн байгууллагуудаас цуглуулсан мэдээлэл</li> <li>● Уг сэдвээр мэдээллийн хэрэгслээр мэдээллэсэн зөвөлгөөн, сургалтын үйл ажиллагаа</li> <li>● Шавь сургалт- дадлагажигчтай тусгай сургалтаар олж авсан мэдлэг ур чадвараа хэрхэн ашиглаж байгааг үнэлэх.</li> </ul>